

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани
ББЭХС	Баруун Бүсийн Эрчим Хүчний Сүлжээ
БЗӨБЦТС	Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ
ЭБЦТС	Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ
ЦДҮС	Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСӨЛ-2”
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Ц.ЧИНЗОРИГ ТАНАА

2020.03.13 № 06/774
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эрчим хүчний төсөл-2” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний төсөл-2”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрчим хүчний төсөл-2” төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төслийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрчим хүчний төсөл-2”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Ц.Чинзориг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт тооцох орлогоос давсан хэмжээний орлогод татварын хөнгөлөлт тооцсоныг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний төсөл-2 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Эрчим хүчний төсөл-2”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Нийслэл-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрчим хүчний төсөл-2”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Эрчим хүчний төсөл-2”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын эрчим хүчний салбар, бүс нутгийн цахилгаан хангамжийг сайжруулах зорилгоор түгээх компаниудын эрчмийн алдагдлыг бууруулж, эдийн засгийн чадавхийг сайжруулах, техникийн найдвартай ажиллагааг хангах, баруун бүсийг байгальд ээлтэй цэвэр эрчим хүчний эх үүсвэрээс дотоодоос хангахад оршино.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (ОУХА) болон Монгол Улсын Засгийн Газар (Сангийн яам төлөөлж оролцсон)-ын хооронд 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдөр “Эрчим хүчний төсөл-2”-ийг хэрэгжүүлэхээр хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн гэрээ байгуулагдсан.

Энэхүү төслөөр ЭБЦТС ТӨХК үйлчилгээ үзүүлдэг Архангай, Өвөрхангай, Булган, Орхон болон БЗӨБЦТС ТӨХК үйлчилгээ үзүүлдэг Багануур дүүрэг, Дундговь, Дорноговь, Хэнтий, Говьсүмбэр аймгууд тус тус хамрагдах бөгөөд ЭБЦТС ТӨХК-д 16,187,000 ам.доллар, БЗӨБЦТС ТӨХК-д 12,583,000 ам.доллар, ББЭХС ТӨХК 25,000,000 ам.доллар (үүнээс 12,400,000 ам.долларын буцалтгүй тусламж), ЦДҮС ТӨХК-д 630,000 ам.долларын санхүүжилт буюу нийт 54,400,000 ам.долларын санхүүжилт хийгдэнэ. Мөн Ховд аймгийн Мянгад суманд 10МВ-ын нарны цахилгаан станцыг барьж байгуулах юм.

Уг төслийн гэрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүрэлдэхүүн хэсэг 1 - Түгээх сүлжээний алдагдлыг бууруулах;
- Бүрэлдэхүүн хэсэг 2 - Нарны цахилгаан станц;
- Бүрэлдэхүүн хэсэг 3 - Чадавхыг нэмэгдүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус нэгжийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Инфосистемс компанийн “MACS” программ хангамж ашигладаг байна.

Төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Эрчим хүчний төсөл-2”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зээлийн хөрөнгөөр санхүүжсэн орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 8,540,864.0 мянган төгрөгөөс тооцон 170,817.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 170,817.3 мянган төгрөгөөр тооцсон нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Эрчим хүчний төсөл-2”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,093,655.4 мянган төгрөгөөр буюу 18.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,803,082.7	4,762,411.0	(1,040,671.7)
Авлага	11,217.7	0.0	(11,217.7)
Үндсэн хөрөнгө	243,680.1	201,914.1	(41,766.0)
Нийт хөрөнгө	6,057,980.5	4,964,325.1	(1,093,655.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,057,980.5	4,964,325.1	(1,093,655.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,057,980.5	4,964,325.1	(1,093,655.4)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1,040,671.7 мянган төгрөгөөр буурсан боловч 4,762,411.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсөл хөтөлбөрт зарцуулах хөрөнгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл буурсан нь банкинд байгаа харилцах дансны 2018 оны эцсээрх үлдэгдэлд тооцсон хүүний авлага болох 11,217.7 мянган төгрөгийг Төрийн банк барагдуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацаанд 41,766.0 мянган төгрөгийн биет болон биет бус хөрөнгийн элэгдлийг байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,964,325.1 мянган төгрөг болж 1,093,655.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 1,093,655.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 9,985,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 9,900,000.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 85,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 9,900,000.0 мянган төгрөгийг гадаадын төслийн зээлээс, 85,000.0 мянган төгрөгийг тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,540,797.3 мянган төгрөг гадаадын төслийн зээлээр санхүүжигдсэн байна. Мөн тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тендерийн баримт, бичгийн борлуулалт хийгдэж 31,730.6 мянган төгрөгийг хүлээн авсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тус төслийн 2019 онд Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээл, тусламжийн санхүүжилтээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд 9,985,000.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 9,810,235.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 8,572,527.9 мянга төгрөг буюу 86 хувьтай, зардлын нийт гүйцэтгэл 9,810,235.7 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь төслийн өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өндөр байгаатай холбоотой ажээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 61.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 61.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 61.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Гадаадын төслийн зээлээс санхүүжигдэж буй зээлийн зарцуулалтын талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төслийн нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 119 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эрчим хүчний төсөл-2”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Эрчим хүчний төсөл-2”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлттэй холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт: Төсөл нь албан татвар ногдуулах жилийн орлого нь 36 сая болон түүнээс дээш орлоготой 3 ажилтны хувь хүний орлогын албан татварт 61.7 мянган төгрөгийн хөнгөлөлтийг тооцож цалинг олгосон. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан албан татварын хөнгөлөлт эдлүүлэх хэмжээтэй нийцэхгүй байна;

3.1.2. Эрсдэл: Ажилтны цалин, хөлс буруу тооцогдох, хувь хүний орлогын албан татвар өр төлбөр дутуу илэрхийлэгдэх, холбогдох хууль зөрчигдөх;

3.1.3 Өгсөн зөвлөмж: Илүү хөнгөлөлт эдлэсэн нэр бүхий төслийн ажилтнуудаас 61.7 мянган төгрөгийг суутган авч татварт тайлагнах;

3.1.1. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч татварт тайлагнана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,814,300,360.20</u>	<u>4,762,410,973.03</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,803,082,671.26	4,762,410,973.03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,803,082,671.26	4,762,410,973.03
31210	Төгрөгөөр	35,355,394.00	63,797,040.00
31220	Гадаад валютаар	5,767,727,277.26	4,698,613,933.03
33000	АВЛАГА	11,217,688.94	-
	Бусад авлага	11,217,688.94	-
33500	Байгууллагаас авах авлага	11,217,688.94	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>243,680,134.40</u>	<u>201,914,089.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>243,680,134.40</u>	<u>201,914,089.90</u>
392	Биет хөрөнгө	238,066,498.05	197,482,271.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	168,636,364.00	168,636,364.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,684,343.44)	(32,790,404.09)
39205	Машин тоног төхөөрөмж компьютер	57,722,273.00	57,722,273.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,405,094.71)	(12,025,473.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,273,597.00	19,273,597.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(476,297.80)	(3,334,084.60)
39300	Биет бус хөрөнгө	5,613,636.35	4,431,818.16
39301	Програм хангамж	5,909,090.90	5,909,090.90
39302	Хуримтлагдсан элэгдэл	(295,454.55)	(1,477,272.74)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,057,980,494.60</u>	<u>4,964,325,062.93</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,057,980,494.60</u>	<u>4,964,325,062.93</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,057,980,494.60	4,964,325,062.93
512	Хуримтлагдсан үр дүн	6,057,980,494.60	4,964,325,062.93
51210	Өмнөх үеийн үр дүн	-	6,057,980,494.60
51220	Тайлант үеийн үр дүн	6,057,980,494.60	(1,093,655,431.67)
6	ӨР, ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,057,980,494.60</u>	<u>4,964,325,062.93</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>6,327,362,379.12</u>	<u>8,701,541,385.72</u>
12	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>6,327,362,379.12</u>	<u>8,701,541,385.72</u>
1200044	Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн орлого	4,322,628,000.00	8,540,864,000.00
122002	Тусламжийн орлого	1,924,492,500.00	
120	Бараа үйлчилгээний орлого	<u>80,241,879.12</u>	<u>160,677,385.72</u>
120002	Хүүгийн орлого	80,241,879.12	128,946,781.72
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		31,730,604.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>718,944,312.26</u>	<u>9,981,023,800.31</u>
210101	Цалин	329,658,710.00	399,394,091.00
210201	Ажил олгогчоос НДШ	39,559,045.00	49,924,261.00
210301	Гэрэл цахилгааны зардал	915,532.10	807,607.00
210301	Түлш халаалтын зардал	999,055.00	1,025,335.00
210301	Цэвэр бохир усны зардал	62,271.00	171,644.00
210401	Бичиг хэргийн зардал	5,257,836.00	2,828,177.00
210402	Тээвэр шатахууны зардал	2,958,000.00	1,060,000.00
210403	Шуудан холбооны зардал	1,532,858.00	1,513,519.00
210702	Дотоод томилолтын зардал	20,483,916.00	59,342,863.00
210804	Төлбөр хураамж жижиг татварууд	48,053.00	192,213.00
210808	Банкны үйлчилгээний хураамж	99,694.68	249,164.40
210604	Урсгал засварын зардал	500,000.00	3,611,999.00
2108	Бусад зардал	14,022,227.00	9,608,631.00
210301	Байрны түрээсийн зардал	45,600,000.00	49,250,000.00
210903	Элэгдлийн зардал	7,861,190.50	41,766,044.51
210901	Зээл, тусламжаар хийгдсэн бусад зардал	249,385,923.98	9,231,331,469.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		128,946,781.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>5,608,418,066.86</u>	<u>(1,279,482,414.59)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	<u>450,884,266.60</u>	<u>219,070,771.15</u>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /бодит/	450,884,266.60	219,070,771.15
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	<u>1,321,838.86</u>	<u>33,243,788.23</u>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз /бодит/	1,321,838.86	33,243,788.23
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	<u>449,562,427.74</u>	<u>185,826,982.92</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>6,057,980,494.60</u>	<u>(1,093,655,431.67)</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,316,095,015.69	8,712,695,617.37
12	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
1200044	Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн орлого	4,322,603,985.40	8,540,797,274.50
122002	Тусламжийн орлого	1,924,466,840.10	
120	Бараа үйлчилгээний орлого	69,024,190.19	171,898,342.87
120002	Хүүгийн орлого	69,024,190.19	140,167,738.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		31,730,604.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	711,033,447.26	9,939,182,450.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ		
210101	Цалин	329,658,710.00	399,394,091.00
210201	Ажил олгогчоос НДШ	39,559,045.00	49,924,261.00
210301	Гэрэл цахилгааны зардал	915,532.10	807,607.00
210301	Түлш халаалтын зардал	999,055.00	1,025,335.00
210301	Цэвэр бохир усны зардал	62,271.00	171,644.00
210401	Бичиг хэргийн зардал	5,257,836.00	2,828,177.00
210402	Тээвэр шатахууны зардал	2,958,000.00	1,060,000.00
210403	Шуудан холбооны зардал	1,532,858.00	1,513,519.00
210702	Дотоод томилолтын зардал	20,483,916.00	59,342,863.00
210804	Төлбөр хураамж жижиг татварууд	48,053.00	192,213.00
210808	Банкны үйлчилгээний хураамж	50,020.18	182,438.90
210604	Урсгал засварын зардал	500,000.00	3,611,999.00
2108	Бусад зардал	14,022,227.00	9,608,631.00
210301	Байрны түрээсийн зардал	45,600,000.00	49,250,000.00
210901	Зээл, тусламжаар хийгдсэн бусад зардал	249,385,923.98	9,231,322,889.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		128,946,781.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,605,061,568.43	(1,226,486,832.93)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	251,541,324.90	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	251,541,324.90	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(251,541,324.90)	0.00
7	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	0.00	0.00
250001	Валютын ханшийн зөрүү	449,562,427.73	185,815,134.71
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,803,082,671.26	(1,040,671,698.22)
9	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,803,082,671.26
10	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,803,082,671.26	4,762,410,973.03

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 01 сарын 31-ээрх үлдэгдэл			-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			6,057,980,494.60	6,057,980,494.60
2018 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл			6,057,980,494.60	6,057,980,494.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(1,093,655,431.67)	(1,093,655,431.67)
2019 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	4,964,325,062.93	4,964,325,062.93

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,985,000,000.00	9,495,473,752.16	489,526,247.84	95.1
УРСГАЛ ЗАРДАЛ	9,900,000,000.00	9,495,473,752.16	404,526,247.84	95.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,900,000,000.00	9,495,473,752.16	404,526,247.84	95.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,900,000,000.00	9,495,473,752.16	404,526,247.84	95.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,900,000,000.00	9,495,473,752.16	404,526,247.84	95.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,000,000.00	-	85,000,000.00	0.0
Гадаад эх үүсвэрээр	85,000,000.00	-	85,000,000.00	0.0
Гадаад эх үүсвэрээр	85,000,000.00		85,000,000.00	0.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,985,000,000.00	8,454,802,053.93	1,530,197,946.07	84.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,900,000,000.00	8,411,850,492.78	1,488,149,507.22	85.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	9,900,000,000.00	8,411,850,492.78	1,488,149,507.22	85.0
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	85,000,000.00	-	85,000,000.00	0.0
Хандив тусламж /гадаад/	85,000,000.00		85,000,000.00	0.0
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	42,951,561.15	(42,951,561.15)	
Туслах үйл ажиллагаанаас	-	42,951,561.15	(42,951,561.15)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,803,082,671.26		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,762,410,973.03		
Байгууллагын тоо	1	1	-	
Төслийн байгууллага	1	1	-	
Нийт ажиллагсад	10	10	-	
Удирдах ажилтан	1	1	-	
Гүйцэтгэх ажилтан	9	9	-	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.27	Аудитын нэр: Эрчим хүчний төсөл-2 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код: САГ-2020/718/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр: ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСӨЛ-2	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Татварын хөнгөлөлт эдлэх орлогоос давсан үндсэн цалингийн орлоготой ажилтнуудад хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг үзүүлсэн.	61.7	Зөвлөмж өгөх	Санхүүгийн ажилтан	Бямба Дэмбэрэл
	ДҮН	61.7			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a summary or conclusion.